



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/47

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “г”, 29.1.4 “д”, 29.1.6 “а”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолын 2, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.14 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөдөө орон нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг аж үйлдвэрийн цахим мэдээллийн санд бүртгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Эрдэнэ-Очир	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд:	Д.Энхтуяа	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Т.Бямбасүрэн	(Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Б.Одонтунгалаг	(Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Жанчивдорж	(Татварын хэлтсийн мэргэжилтэн)
	Д.Ганчимэг	(Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Дундговь салбарын дарга)
Нарийн бичгийн дарга:	Ж.Мөнхбаяр	(Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Хоёр. Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн системд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн “С” ангиллын боловсруулах үйлдвэрүүдийг бүртгэх ажлыг 2021 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 01-ний хооронд түргэн шуурхай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210095